



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2021.03.30 № 178

танай _____-ны № _____-т

ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Г.БОЛОРМАА ТАНАА

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу танай байгууллагын 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитын тайлан, дүгнэлт, менежмент захидлыг хүргүүлээ. Шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.УЛАМБЯЯ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020
оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/16/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Цэцэрлэг хот

2021 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд тэргүүлэх аудитор: Д. Уламбаяр

Утас: 70333141 UlambayarD@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860 BaigalmaaT@audit.gov.mn

Аудитор: Х.Алтанчимэг

Утас:90060105 Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын гэрчилгээ.....	6
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3.Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	11
3.5.3 Авлага	11
3.5.6 Бараа материал	12
3.5.7 Үндсэн хөрөнгө	13
3.5.8 Өр төлбөр	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	15
3.5.10 Орлогын данс	15
3.5.11 Зардлын данс.....	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	20
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	21
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	23
4. Менежментийн захидал	23
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан

1. Аудитын гэрчилгээ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Г.БОЛОРМАА ТАНАА

2021.03.30 № 135
танай _____ -ны № _____ -Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төвшрүүлэх сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төвшрүүлэх сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



← ДУЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	723,945.3	744,880.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	123,537.4	142,317.8
33	АВЛАГА	369,729.5	351,273.0
35	БАРАА МАТЕРИАЛ	228,728.4	243,855.5
36	НӨӨЦИЙН БАРАА	1,950.0	7,434.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,336,162.6	7,402,215.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,336,162.6	7,402,215.1
39200	Биет хөрөнгө	7,207,516.6	7,272,538.4
39300	Биет бус хөрөнгө	128,646.0	129,676.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,060,108.0	8,147,095.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,264.1	1,218.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,264.1	1,218.0
41300	Өглөг	1,264.1	1,218.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,058,843.9	8,145,877.5
51	Засгийн газрын хувь оролцоо	8,058,843.9	8,145,877.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,960,265.7	1,960,265.7
51200	Хуримтлагдсан үр дүн	3,554,047.6	3,641,081.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,544,530.6	2,544,530.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,060,108.0	8,147,095.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,509,697.1	2,828,665.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	200,499.4	122,521.1
110	Орлогын албан татвар	45,663.5	75,430.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	45,663.5	75,430.0
113	Хөрөнгийн албан татвар	1,530.0	2,040.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	153,305.9	45,051.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	931,709.9	374,133.0
120	Нийтлэг татварын бус орлого	931,709.9	374,133.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,377,487.8	2,332,011.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,709,181.2	2,658,722.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,709,181.2	2,658,722.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,233,825.0	2,604,318.0

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,416,223.7	1,620,925.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,252.9	202,042.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,276.5	135,209.7
2104	Хангамж, бараа материалын зардал	58,987.9	103,548.6
2105	Нормативт зардал	109,324.0	105,208.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,150.5	19,713.8
2107	Томилолт, зочны зардал	6,672.6	3,396.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,048.1	70,349.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	306,888.9	343,923.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	475,356.2	54,404.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	800,515.9	169,942.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,844.2	82,909.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	776,671.8	87,033.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,692,965.3	2,506,090.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	200,499.4	122,521.1
110	Орлогын албан татвар	45,663.5	75,430.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	45,663.5	75,430.0
113	Хөрөнгийн албан татвар	1,530.0	2,040.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	153,305.9	45,051.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	26,426.4	25,173.6
1181	Газрын төлбөр	107,436.2	5,636.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	19,443.4	14,240.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,878.1	51,558.2
120	Нийтлэг татварын бус орлого	114,878.1	51,558.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,377,587.8	2,332,011.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,454,817.3	2,335,663.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,454,817.3	2,335,663.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,979,257.2	2,281,260.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,416,052.2	1,620,925.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,976.2	204,954.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,243.1	134,488.8

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	48,333.8	79,901.9
2105	Нормативт зардал	117,265.4	89,308.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,210.0	17,275.0
2107	Томилолт, зочны зардал	6,672.6	3,396.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,629.8	79,855.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,874.1	51,155.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	475,560.1	54,402.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	238,147.9	170,427.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	55,597.4	151,646.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,597.4	151,646.9
2200	Дотоод эх үүсвэрээр	55,597.4	151,646.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-55,597.4	-151,646.9
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	82,550.5	18,780.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,986.9	123,537.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	123,537.4	142,317.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-н	7,282,172.1	7,282,172.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,548.3	1,548.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,283,720.4	7,283,720.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,548.3	-1,548.3
9	Тайлант үеийн үр дүн	776,671.8	776,671.8
10	2019 оны 12-р сарын 31	8,058,843.9	8,058,843.9
11	2020 оны 1-р сарын 1	8,058,843.9	8,058,843.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,058,843.9	8,058,843.9
19	Тайлант үеийн үр дүн	87,033.6	87,033.6
20	2020 оны 12-р сарын 31	8,145,877.5	8,145,877.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,732,721.40	2,399,975.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,359,146.30	2,317,066.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,332,814.00	2,296,319.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,624,046.40	1,620,925.31

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	211,528.30	204,954.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,790.30	133,460.78
2104	Хангамж, бараа материалын зардал	68,259.30	62,461.58
2105	Нормативт зардал	101,240.60	89,307.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,223.10	36,223.10
2107	Томилолт, зочны зардал	4,438.90	3,396.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,940.80	54,244.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,346.30	91,345.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,332.30	20,746.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,332.30	20,746.98
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,025.20	82,908.98
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,732,721.40	2,446,419.60
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,576,454.70	1,554,035.44
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	746,467.30	813,374.62
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,245.30	30,845.20
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	376,554.10	48,164.33
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	32,234.18
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	78,677.98

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,906.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,906.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,678.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,028.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,590.32
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,975.46
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,085.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,227.50
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,227.50
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	68,906.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,906.28

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Г.Болормаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 22-оос 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэв.

Төвшрүүлэх сумын ТЕЗ нь 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төвшрүүлэх сумын ТЕЗ нь тайлант жилд “Оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжлийг тодорхойлж, хэрэгжилтийг ханган төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй хүргэх” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоол
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар тогтоол
- “Автомашинны жишиг норм батлах тухай” Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд 6 төсвийн байгууллага, 2 төсөл сан, 1 орон нутгийн орлогын санхүүгийн тайланг нэгтгэж нэгтгэлийг онлайнээр бэлтгэж байна.

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдлийн түвшинг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд шинж чанар ба агуулгын хувьд өөрчлөлт ороогүй тул төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин болох үр дүнгийн тайлангийн нийт зардал **2,741,956.5** мянган төгрөгийн 1 хувь **27,419.5** мянган төгрөгөөр тооцлоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл **123,537.4** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **142,317.8** мянган төгрөг болж, **18,780.4** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Төрийн сангийн харилцах	123,537.40	142,317.80	18,780.40
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	123,537.40	142,317.80	18,780.40
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
Сум хөгжүүлэх сан	7,153.20	29,561.80	22,408.60
Орон нутгийн ерөнхий орлого	91,303.30	63,639.80	-27,663.50
Орон нутгийн хөгжлийн сан	25,081.00	49,116.20	24,035.20
НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН	123,537.50	142,317.80	18,780.30

Эх сурвалж: Төвшрүүлэх сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 21.0 хувь буюу 29,561.8 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн, 45.0 хувь буюу 63,639.8 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлого, 35.0 хувь буюу 49,116.0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл тус тус эзлэж байна.

3.5.2 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 369,729,5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 351,273,0 мянган төгрөгийг тайланд тусгасан ба авлага 18456,5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт(-)
Байгууллагаас авах авлага	97.9	2,807.00	2,709.10
Хувь хүмүүсээс авах авлага	369,631.60	348,466.00	-21,165.60
Нийт дүн	369,729.50	351,273.00	-18,456.50
Үүнээс: Байгууллагын төрлөөр ангилбал			
Ахлах сургууль	97.9	2,113.40	2,015.50
Сум хөгжүүлэх сан	369,631.60	348,466.00	-21,165.60
Хүүхдийн цэцэрлэг	0.00	693.60	693.60
Нийт дүн	369,729.50	351,273.00	-18,456.50

Эх сурвалж: Төвшрүүлэх сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 99.2 хувь буюу 348,466.0 мянган төгрөгийг СХС-ийн зээлийн авлага эзлэж байгаа бол, 0.8 хувь буюу 2,807.0 мянган төгрөгийг ахлах сургууль, цэцэрлэгийн НДШ-ийн илүү төлөлтийн авлага эзлэж байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Хүүхдийн цэцэрлэг- Тэтгэвэр тогтоолгосон хүний 693,6 мянган төгрөгийн НДШ-ийг илүү тооцон шилжүүлж шимтгэлийн авлага үүсгэсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 45.2 Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл **228,728.4** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **243,855.5** мянган төгрөг болж **15,127.0** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	13,956.60	12,167.00	-1,789.60
Эм боох материал	6,969.20	16,586.10	9,616.90
Бичиг хэргийн материал	8,051.60	9,469.60	1,418.00
Аж ахуйн материал	174,589.30	182,634.90	8,045.60
Сэлбэг хэрэгсэл	3,469.50	5,710.00	2,240.50
Түлш шатах тослох материал	6,672.10	7,860.50	1,188.40
Барилгын засварын материал	3,624.70	1,487.00	-2,137.70
Хүнсний материал	4,268.70	525.10	-3,743.60
Бусад хангамжийн материал	7,126.80	7,415.30	288.50
Дүн	228,728.50	243,855.50	15,127.10
Үүнээс байгууллагын төрлөөр:			
Ахлах сургууль	68,695.40	86,043.40	17,348.00
ЗДТГ	46,662.30	46,887.40	225.10
ИТХ	1,409.10	1,367.90	-41.20
Сум хөгжүүлэх сан	1,764.00		-1,764.00
Соёлын төв	28,325.00	27,023.80	-1,301.20
Хүүхдийн цэцэрлэг	38,144.70	42,412.80	4,268.10
Эрүүл мэндийн төв	43,727.90	40,120.20	-3,607.70
Дүн	228,728.40	243,855.50	15,127.10

Эх сурвалж: Төвшрүүлэх сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 35.0 хувь буюу 86,043.4 мянган төгрөгийн бараа материалыг ахлах сургууль, 19.0 хувь буюу 46,887.4 мянган төгрөгийн бараа материалыг ЗДТГ, 11.0 хувь буюу 27,023.8 мянган төгрөгийг Соёлын төв, 17.0 хувь буюу 42,412.8 мянган төгрөгийн бараа материалыг хүүхдийн цэцэрлэг, 16.0 хувь буюу 40,120.2 мянган төгрөгийн бараа материалыг ЭМТ эзлэж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 303,232.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар 40,899.8 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 1,636.2 мянган төгрөгийн материал орлогод авсан бөгөөд 329,043.4 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 1,579.9 мянган төгрөгийн материалыг данс хооронд шилжүүлж нийт 330,641.3 мянган төгрөгийн материал зарцуулагдсан байна.

Тус сумын ЗДТГ-т тайлант жилд 7434.0 мянган төгрөгийн нөөцийн бараа бүртгэлтэй байгаа нь өвөлжилтийн бэлэн байдлыг хангаж ажиллахтай холбогдсон аймгийн засаг шийдвэрийн дагуу бүрдүүлсэн өвс, хорголжин тэжээлийн нөөцийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой дараах зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

1. ЭМТ- Аудитын тайлангийн хугацаанаас хойш бараа материалын тайланд 8,681.7 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийг орлогод авч тайланд залруулга хийлгэв.
2. Хүүхдийн цэцэрлэг- Санхүүгийн тайланд 2249.8 мянган төгрөгийн барилгын засварын материалыг барилга байгууламж, орон сууц дансанд бүртгэснийг залруулга хийлгэв.
3. Хүүхдийн цэцэрлэг-Түлээ нүүрсний үлдэгдэл 2,685.0 мянган төгрөгийг тайланд үлдэгдлээр тусгуулаагүй байсанд үлдэгдлээр тусгуулж залруулга хийлгэв
4. Соёлын төв- Бараа материалын тодруулга тайлангийн эхний, эцсийн үлдэгдлээр Аж ахуйн материал 24,248.6 мянган төгрөг, Түлш шатах тослох материал 1,253.1 мянган төгрөг, Бусад хангамжийн материал 1,778.1 мянган төгрөг байхад Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн эхний, эцсийн үлдэгдэлээр аж ахуйн материал 18,776.0 мянган төгрөг, Түлш шатах тослох материал үлдэгдэлгүй байна. Харин оны эцсийн тооллогын бүртгэлээр аж ахуйн материалын эцсийн үлдэгдэл 18,289.6 мянган төгрөг, түлш шатах тослох материалын эцсийн үлдэгдэл байхгүй байна. /БМТ:24,248.6- БМДэл:18,776.0=5,472.6/+БМТ: 1778.1-БМДэл 4,943.4=3,165.3/+1253.1=9,891.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсанг Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын явцад залруулсан байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл **7,336,162.6 мянган төгрөг**, эцсийн үлдэгдэл **7,402,215.1** төгрөг болж 18.1 хувь буюу 536,897.3 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт үндсэн хөрөнгийн 96.0 хувийг биет хөрөнгө, 4.0 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Биет хөрөнгө	7207516.6	7,272,538.40	65,021.80
Биет бус хөрөнгө	128646	129,676.70	1,030.70
Дүн	7,336,162.6	7,402,215.1	66,052.50
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Ахлах сургууль	3,381,759.7	3,394,338.8	12,579.10
ЗДТГ	1,530,213.9	1,649,402.7	119,188.80
ИТХ	2,691.9	2,121.7	(570.20)
Соёлын төв	1,036,646.6	1,019,304.8	(17,341.80)
Хүүхдийн цэцэрлэг	357,864.1	328,215.1	(29,649.00)
ЭМТ	1,026,986.4	1,008,832.0	(18,154.40)
Дүн	7,336,162.6	7,402,215.1	66,052.50

Эх сурвалж: Төвшрүүлэх сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 46.0 хувь буюу 3,394,338.8 мянган төгрөгийн хөрөнгийг ахлах сургууль, 22.0 хувь буюу 1,649,402.7 мянган төгрөгийн хөрөнгийг ЗДТГ, 14.0 хувь буюу

1,019,304.8 мянган төгрөгийн хөрөнгийг Соёлын төв, 4 хувь буюу 328,215.1 мянган төгрөгийг хүүхдийн цэцэрлэг, 14.0 хувь буюу 1,008,832.0 мянган төгрөгийн хөрөнгийг ЭМТ эзэмшиж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 68,738.0 мянган төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 1,200.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 297,840.6 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс авсан 120.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн бол балансаас баланст шилжүүлсэн, акталсан хөрөнгө байхгүй байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. Соёлын төв- 1,008,831.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн программын бааз устаж дахин бүртгэл хийхдээ хөрөнгийг бөөн дүнгээр нь бүртгэсэн байсныг залруулга хийлгэж нэр төрлөөр нь бүртгэл тайланд тусгалаа.
2. Соёлын төв- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас үзэхэд эхний үлдэгдэл 19,532.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 16,024.9 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 13,839.9 мянган төгрөгийн ном, 27,345.8 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 76,743.5 мянган төгрөгийн хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэсэн байна.
3. ЗДТГ-ийн санхүүгийн тайланд элэгдлээ бүрэн нөхсөн 7 нэр төрлийн 46,649.9 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 52 нэр төрлийн 50,504.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 36 нэр төрлийн 12,168.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 31 нэр төрлийн 80,955.8 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 6 нэр төрлийн 1474.5 мянган төгрөгийн нийт 132 нэр төрлийн 191,752.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна
4. ИТХ-ын санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөнд 2,932.3 мянган төгрөгийн тавилга, 4,097.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийт 7,030.2 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ нөхсөн үлдэх хөрөнгөгүй байна.
5. ЭМТ-ийн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 83 нэр төрлийн нийт 86,884.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
6. Хүүхдийн цэцэрлэг-Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 32,922.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Дээрх элэгдлээ нөхсөн хөрөнгүүд нь ТБОНӨТХ-ийн 31 дэхь заалт, Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны заавартай нийцэхгүй байгаа тул аудитаас менежмент захидлаар зөвлөмж хүргүүлсэн байна.

3.5.8 Өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл **1,264.1 мянган төгрөг**, эцсийн үлдэгдэл 1,218.0 төгрөг болж 46.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Байгууллагад төлөх өглөг	1,264.10	1,218.00	-46.10
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Ахлах сургууль	3.8	0.00	-3.80
Цэцэрлэг	302.00	121.7	-180.30
Эрүүл мэндийн төв	958.30	1096.3	138.00
ДҮН	1,264.10	1,218.00	-46.10

Эх сурвалж: Төвшрүүлэх сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 121.7 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн түлш халаалтын, 1096.3 мянган төгрөг нь ЭМТ-д даатгалын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотойгоор үүссэн эм бэлдмэлийн, цалингийн сангаас 3 хүний сахилгын шийтгэл суутгасан боловч орон нутгийн орлогот шилжүүлээгүй үүссэн өр төлбөр байна.

Аудитын илрүүлэлт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. ЭМТ- тайлант жилд 1,096.2 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнасан байна. Шалтгаан нь 3 албан хаагчийн сахилгын шийтгэлийн дүнг орон нутгийн харьяагдах дансанд төвлөрүүлээгүй, мөн Ази фарм ХХК-д эм бэлтгэн нийлүүлсэн өмнөх оны үлдэгдэл өр төлбөрийг барагдуулаагүй байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл **8,058,843.9** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **8,145,877.5** мянган төгрөг болж, **87,033.6** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Цэвэр хөрөнгө өмчийн дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	1,960,265.70	1,960,265.70	0.00
Хуримтлагдсан үр дүн	3,554,047.60	3,641,081.20	87,033.60
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,544,530.60	2,544,530.60	0.00
Дүн	8,058,843.90	8,145,877.50	87,033.60

Эх сурвалж: Төвшрүүлэх сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн өмнөх оноос 87,033.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Төвшрүүлэх сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 2,828,665.1 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 681,032.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 122,521.6 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 374,133.0 мянган төгрөг байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 2,332,011.0 мянган төгрөг байна. Үүнээс: Улсын төсвөөс 1,572,315.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 68,906.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 659,944.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 30,845.2 мянган төгрөг

3.5.11 Зардлын данс

Төвшрүүлэх сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 2,604,318.0 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 82,909 мянган төгрөг нийт 2,658,722,6 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 87,033.6 мянган болж буурсан байна. Тайлант жилд 494,952.8 мянган төгрөгийн санхүүжилт хоорондын тооцоог устгах бичилтээр хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. ЗДТГ- Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 3098.6 мянган төгрөгийг баяр наадмын зардалд зарцуулсан нь ЗДНХ-ийн журмын 1.1 дэх заалт, ЗГ-ын 2010 оны “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалт, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.
2. ЗДТГ- Аймгийн засаг даргын нөөц сангаас 5,000.0 мянган төгрөгийн ковид-19 цар тахалтай холбогдуулан зарцуулахаар хуваарилсан зардлаас 1,200.0 мянган төгрөгөөр 1 иргэнд гэр худалдан авч өгсөн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй байна.
3. ИТХ- Шатахууны зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад 4-р сараас хойш жолоочийн тооцооны хуудас, шаардах хуудас зэрэгт холбогдох жолоочийн гарын үсгийг дутуу бичиж, анхан шатны баримтад тавих хяналтыг дутуу хэрэгжүүлсэн байна.
4. ЭМТ- тайлант онд тээвэр шатахуун 9,312.1 мянган төгрөгийн зарцуулсан бөгөөд жолоочийн тооцооны хуудсаар хэтрэлт хэмнэлт тооцоогүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.
5. ЭМТ-ХХОАТ-ын тухай хуулийн дагуу хөнгөлөлт тооцох хэмжээг тухайн саруудад зарим албан хаагчдын цалингаас зөрүүтэй тооцсон байна.
6. Ахлах сургууль- Нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн
7. Ахлах сургууль-Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэн шилжүүлэг болох 12,817.4 мянган төгрөгийг тайлагнаагүй байсныг залруулав.
8. Хүүхдийн цэцэрлэг- Түлшний зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 1000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэлгүй түлээ, нүүрс бэлтгэсэн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
9. Мөн Бүх төсөвт байгууллагад дотоод хяналт шалгалт хийгдээгүй, дотоод хяналт сул байгаа тул менежмент захидлаар зөвлөмж хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчдын дээрх зөрчилд холбогдох шийдвэрүүдийг хүргүүлсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

✓ **Орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Орон нутгийн төсвийн орлогыг 49,193.2 мянган төгрөгөөр анх төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг 20,758.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 69,952.0 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Харин төсвийн төслийг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулахад 127,191.5 мянган төгрөгөөр, анх баталсан төсвийг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулахад 106,432.7 мянган төгрөгөөр тус тус дутуу төсөвлөсөн байна.

Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөвт зохицуулалт хийх тухай тухай 05-р тогтоолд сумын төсвийн орлогоор 16 нэр төрлийн 62,434.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 74,385.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 19.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Сумын орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
0	НИЙТ ОРЛОГО	62,434.00	74,385.60	11,951.60	1.19
1	Үйл ажиллагааны орлого	11,000.00	10,677.30	(322.70)	0.97
2	Шууд бус орлого	15,740.00	37,552.20	21,812.20	2.39
3	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүүнээс/	17,640.00	25,564.10	7,924.10	1.45
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	150.00	1,636.50	1,486.50	10.91
5	Бууны албан татвар	2,070.00	2,040.00	(30.00)	0.99
6	Улсын тэмдэгтийн хураамж	2,440.00	2,247.80	(192.20)	0.92
7	Газрын төлбөр	2,439.00	5,636.80	3,197.80	2.31
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	15,474.00	20,000.00	4,526.00	1.29
9	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,990.00	2,925.80	(2,064.20)	0.59
10	Байгалийн ургамал ашигласны төлбөр	60.00	343.00	283.00	5.72
11	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2,000.00	2,000.00	-	1.00
12	Ойн нөөц ашигласны төлбөр	11,095.00	11,801.70	706.70	1.06
13	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	66.00	66.00	-	1.00
14	Төсөвт газрын өөрийн орлого	20,620.00	23,930.70	3,310.70	1.16
15	Хүү торгуулийн орлого	680.00	2,718.80	2,038.80	4.00
16	Нэр заагдаагүй бусад орлого	500.00	675.00	175.00	1.35

Тайлант жилд 12 нэр төрлийн орлого давж биелэсэн бол 4 нэр төрлийн орлого тасарсан байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны орлогод иргэний орлогын албан татварын ногдуулалт хийгдсэн ба газрын эрх шилжүүлсэний татвар нэмэгдэж төлөвлөгдсөн тул орлогын зүйл анги өөрчлөгдөж хөрөнгө борлуулсны татвар дээр орлого нь төвлөрч орсон тул тус орлого 322.7 мянган төгрөгөөр,
2. Бууны орлогод буугаа зарсан боловч татварын албанд хасалт хийлгээгүй 1 иргэнтэй холбоотойгоор 30.0 мянган төгрөгөөр,
3. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогод Байгаль орчноос албанаас түлшний гоожингийн тэмдэгтийн хураамж, Нотариатын үйлчилгээний орлого, мал эмнэлэгийн махны бичгийн тэмдэгтийн хураамжийн орлого орсон. Цар тахлын улмаас иргэний бүртгэлийн үйл ажиллагаа цахимжин харьяалал харгалзахгүй хийдэг болсоноор иргэд бүртгэл хийлгэх нь багассан тул орлого тасарсан байна. Мөн банкны зээлийн гэрээнд өөрчлөлт орж нотариат хийлгэх нь багассантай холбоотойгоор 192.2 мянган төгрөгөөр
4. Хог хаягдлын үйлчилгээний орлогод иргэн тус бүрээр төлөх төлөвлөгөө гарсанаар ААНБайгууллага, айл өрх бүрээр ногдуулалт гарган хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэн ажилласан ч сумаас шилжсэн боловч хүн ам өрхийн бүртгэлээс хасалт хийлгээгүй өрхүүдээс шалтгааланаар 2,064.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Иймд орон нутгийн төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Төсвийн төлөвлөлт

Төвшрүүлэх сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 2,811,369.7 мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 2,718,773.4 мянган төгрөг болж 92,596.3 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт 8. Сумын төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн татварын орлого	80,462.0	106,964.0	26,502.0
1.1	Татварын орлого	79,282.0	85,164.0	5,882.0
1.2	Сумын төсвийн татварын бус орлого	1,180.0	1,180.0	-
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,620.0	20,620.0	-
	Нийт дүн	260,169.9	260,169.9	-
3 Санхүүжих зарлагын эх үүсвэр				
3.1	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	331,477.5	314,179.6	(17,297.9)
3.2	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	86,276.6	106,944.3	20,667.7
3.3	СӨБ-ийн үйлчилгээ	346,183.3	317,913.8	(28,269.5)
3.4	ЕБС-ийн үйлчилгээ	1,074,368.3	977,150.0	(97,218.3)
3.5	Соёлын үйлчилгээ	114,257.6	114,257.6	-
3.6	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	426,330.5	425,430.0	(900.5)
3.7	2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	73,762.8	91,303.3	17,540.5
3.8	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	18,081.2	25,080.9	6,999.7
	Нийт дүн	2,811,369.7	2,718,773.4	(92,596.3)
4. Төсөв захирагчийн зарцуулах дүн				
4.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	71,088.3	71,088.3	-
4.2	Засаг даргын тамгын газар	435,234.0	441,358.6	6,124.6
4.3	Орон нутгийн нөөц хөрөнгө			-
4.4	Орон нутгийн хөгжлийн сан	104,357.8	132,025.2	27,667.4
4.5	Сум хөгжүүлэх сан	237,049.9	237,049.9	-
4.6	Сургуулийн өмнөх боловсрол	346,183.3	317,913.8	(28,269.5)
4.7	Ерөнхий боловсролын сургууль	1,074,368.3	977,150.0	(97,218.3)
4.8	Соёлын төв	116,757.6	116,757.6	-
4.9	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	426,330.5	425,430.0	(900.5)
	Нийт дүн	2,811,369.7	2,718,773.4	(92,596.3)

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн шууд бус орлогыг 13,400.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 5,616.0 мянган төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг, 1,836.0 мянган төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 66.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Харин төсвөөс авах санхүүжилтийн эх үүсвэрийг 98,478.3 мянган төгрөгөөр бууруулж 2,372,259.5 мянган төгрөгөөр баталсан нь Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай холбоотой, мөн томилолтын, зочид төлөөлөгч хүлээн авах, урсгал засварын, хөрөнгийн зэрэг зардлууд зарцуулагдахааргүй болсонтой холбоотой байна.

✓ **Орон нутгийн төсвийн зардлын талаар:**

Төвшрүүлэх сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 08 тоот тогтоолоор 2,811,369.7 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор төсвийн зохицуулалт хийж ТЗШ-ийн байгууллагаас 126,38.3 мянган төгрөгийг хасах тодотгол хийсэн бол, ЗДТГ-т 6,124.6 мянган төгрөгийн, ОНХС-д 27,667.5

мянган төгрөгийн нэмэх тодотгол тус тус хийж нийт зардлыг 2,718,773.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Гэтэл төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,732,721.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь 12-р сард ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт сангийн яам зохицуулалт хийж буцаан татаж, өртэй гарах зардлуудад тодотгол хийсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын 1,576,454.7 мянган төгрөг буюу 57.6 хувийг тусгай зориулалтын шилжүүлэгээс, 746,467.3 мянган төгрөг буюу 27.4 хувийг орон нутгийн төсвөөс, 33,245.2 мянган төгрөг буюу 1.3 хувийг НДС-аас 376,554.1 мянган төгрөг буюу 13.7 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,399,975.8 мянган төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь урсгал зардлаас 42,079.5 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 55,116.2 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 235,549.9 мянган төгрөг хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

✓ **Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн талаар:**

1. ОНХС-аар 2020 онд 15 төсөл арга хэмжээнд нийт 132,025.2 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 82,908.9 мянган төгрөг зарцуулагдсан байна. Үүнээс барилга байгууламжид 56,800.0 мянган төгрөг, их засварт 45,557.8 мянган төгрөг, тоног төхөөрөмжид 29,667.4 мянган төгрөг тус тус зарцуулж 49,116.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус сумын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг нийцлийн аудитаар үзэж байна.
2. Сум хөгжүүлэх санд нийт 135 хүнтэй холбоотой 348,466.0 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хэвийн зээл 37 хүнтэй холбоотой 161,777.5 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 31 хүнтэй холбоотой 86,300.0 мянган төгрөг, чанаргүй зээл 67 хүнтэй холбоотой 100,388.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд 23,033.6 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрсөн нь ИТХ-аар баталсан дүнгээс хэт бага, зээлийн авлага төвлөрүүлэлт, зээл олголт, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд хангалтгүй байгаа тул аудитаас тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсөв захирагчаас 46,900.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 22,006.3 мянган төгрөг нийт 68,906.3 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр ирсэн санхүүжилтээс бараа үйлчилгээний зардалд 53,678.7 мянган төгрөгийг, урсгал шилжүүлэгт 15,227.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих .132 мэдээллээс 127 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. ЗДТГ- Шилэн дансны цахим хуудаст 87 мэдээллийг хугацаанд нь 61 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан
2. ИТХ-Шилэн дансны цахим хуудаст 89 мэдээллийг хугацаанд нь 60 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан
3. ЭМТ- Шилэн дансны цахим хуудаст 104 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг тухай бүр оруулаагүй, төсөв хөрөнгөтэй холбоотой 7,247.4 мянган төгрөгийн 15 тушаалыг цахим системд байршуулаагүй
4. Хүүхдийн цэцэрлэг- Шилэн дансны цахим хуудаст 126 мэдээллийг хугацаанд нь 16 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мөн бүтэн жилийн санхүүгийн тайлан, дүгнэлт, аудитын дүгнэлт зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг мэдээллийг мэдээлээгүй.
5. Соёлын төв- Шилэн дансны цахим сайт алдаа заан нэвтрэх боломжгүй байгаа тул Санхүүгийн хяналт аудитын албанаас 2020 оны эхний 3 дугаар улирлын байдлаар хийсэн шалгалтын дүнгээс авлаа. Төвшрүүлэх сумын соёлын төв нь нийт мэдээлбэл зохих 111-ээс мэдээлэл оруулсан 106 үүнээс 64 мэдээлэл хугацаандаа, 42 мэдээлэл хугацаа хоцроосон, 13,414.2 мянган төгрөгийн 6 тушаал шийдвэр мэдээлээгүй байна.
6. Ахлах сургууль-Шилэн дансны хуулийн дагуу 145 мэдээлэл оруулахаас 17 мэдээлэл хугацаа хоцроосон

Төвшрүүлэх сумын ТЕЗ-ын харьяа төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хангалтгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар 147,876.8 мянган төгрөгийг аудитын явцад залруулж, 954,612.1 мянган төгрөгийн зөрчилд аудитын шийдвэр хүргүүлсэн байна.

Хүснэгт №9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/мянган төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	9,537.9	1	9,537.9			75.0
Зөвлөмж	1	185,760.6	1	185,760.6			50
Нийт	2	195,298.6	2	195,298.6			

1. Өмнөх онд Төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзэхэд 7 нэр төрлийн орлого 9,537.9 мянган төгрөгөөр тасарсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн бол тайлант жилд ковид-19 цар тахал гарч 4 нэр төрлийн орлого 2608.9 мянган төгрөгөөр тасарсан тул биелэлтийг 75%-тай гэж үзэн

аудитын зүгээс орлогын төлөвлөлт болон нэр төрлөөр жигд ханган биелүүлэх зөвлөмж хүргүүлж байна.

2. Төвшрүүлэх сумын ТЕЗ нь СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга авах арга хэмжээ авч ажиллаж байгаа гэсэн албан бичгээр зөвлөмжийн хариуг ирүүлсэн, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 85,372.0 мянган төгрөгөөр буурсан хэдий ч СХС-аас эргэн төвлөрөх зээл хангалтгүй байгаа тул аудитаас ахин зөвлөмж хүргүүлэн ажиллах нь зүйтэй гэж үзсэн.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Төвшрүүлэх сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №10.Аудитын дүнгийн талаар:

Аудитын нэр	Аудитын санал дүгнэлтийн төрөл			
	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс Зөрчилгүй
	Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулс ан		
ЗДТГ	1		1	1
ИТХурал	1		1	1
ЭМТ	1		1	1
Соёлын төв		1		
ЕБС	1		1	1
Хүүхдийн цэцэрлэг		1		
НИЙТ ДҮН	4	2	4	4

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 6 төсөвт байгууллагыг аудитад хамруулж 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,504,259.3 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч 1,035,265.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 354,609.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 112,690.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,693.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт №11. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Аудитын нэр	Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ			5	196,051.40			2	4,298.60	3	191,752.80
ИТХурал			3	7,030.20			1		2	7,030.20
ЭМТ	2	1,017,513.60	6.0	104,540.40			2	8,343.60	4	96,196.80
Соёлын төв			2.0	100,048.70			2	100,048.70		

Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ахлах сургууль	1	12,817.40	3.0	26,707.00			1		2	26,707.00
Хүүхдийн цэцэрлэг	2	4,934.80	3.0	34,615.80	1	1,693.60	1	-	1	32,922.20
НИЙТ ДҮН	5	1,035,265.8	22	468,993.50	1	1,693.6	9	112,690.9	12	354,609.0

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Төвшрүүлэх сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 189,297.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 9,891.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 189,297.5 мянган төгрөгийн зөрчилд менежмент захидлаар зөвлөмж хүргүүллээ.

Хүснэгт №12 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Аудитын нэр	Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт			
					Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СХСан			1	186,688.60			1	186,688.60
Нэгдсэн тайлан	1	9,891.00	1	2,608.90	1	9,891.00	1	2,608.90
НИЙТ ДҮН	1	9,891.00	2	189,297.50	1.00	9,891.00	2.00	189,297.50

1. Төвшрүүлэх сумын орон нутгийн 4 нэр төрлийн 2,608.9 мянган төгрөгийн орлого ковид-19 цар тахалтай холбогдуулан тасарсанд аудитаас зөвлөмж хүргүүллээ.
2. СХС-ийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 85,372.0 мянган төгрөгөөр буурсан хэдий ч СХС-аас эргэн төвлөрөх зээл хангалтгүй байгаад аудитаас менежмент захидлаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.
3. Аудитын явцад тус сумын соёлын төвийн санхүүгийн бараа материалын тайлангийн үлдэгдэл зөрүүтэй байсанд аудитаас зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, ТЭЗ-д тайланд залруулга хийлгэлээ.

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитад төсөв батлах тухай тогтоолыг үнэн зөв хийсэн эсэхийг нягтлах

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ОРЛОГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 **Илрүүлэлт:** Тайлант жилд 12 нэр төрлийн орлого давж биелэсэн бол 4 нэр төрлийн орлого тасарсан байна. Үүнд: Үйл ажиллагааны орлого 322.7 мянган төгрөгөөр, Бууны орлого 30.0 мянган төгрөгөөр, Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 192.2 мянган төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний 2,064.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

3.1.2 **Эрсдэл:** Орон нутгийн орлого дутуу төвлөрөх

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 41.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэн төсөвт төвлөрөх орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, орлогыг жигд ханган биелүүлж ажиллах.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 АВЛАГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ:

3.2.1 **Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх санд нийт 135 хүнтэй холбоотой 348,466.0 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хэвийн зээл 37 хүнтэй холбоотой 161,777.5 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 31 хүнтэй холбоотой 86,300.0 мянган төгрөг, чанаргүй зээл 67 хүнтэй холбоотой 100,388.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд 23,033.6 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрсөн нь ИТХ-аар баталсан дүнгээс хэт бага, зээлийн авлага төвлөрүүлэлт, зээл олголт, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд хангалтгүй байна.

3.2.2 **Эрсдэл:** Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.




3.2.3 **Өгсөн зөвлөмж:** *Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах*

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН

Бэлтгэсэн:	Аудитор		Х.Алтанчимэг
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор		Д.Уламбаяр

1 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр: Төвшрүүлэх сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн	Аудитын код: АРА-2021/16/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Төвшрүүлэх сумын ТЕЗ	мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Тайлант жилд 12 нэр төрлийн орлого давж биелэсэн бол 4 нэр төрлийн орлого тасарсан байна. Үүнд: Үйл ажиллагааны орлого 322.7 мянган төгрөгөөр, Бууны орлого 30.0 мянган төгрөгөөр, Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 192.2 мянган төгрөгөөр, Хог хаягдлын үйлчилгээний 2,064.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна	2608.9	Менежмент захидлаар зөвлөмж хүргүүлэв.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Г.Болормаа, Б.Алтанцэцэг
2	Сум хөгжүүлэх санд нийт 135 хүнтэй холбоотой 348,466.0 мянган төгрөгийн зээлийн авлагатайгаас хэвийн зээл 37 хүнтэй холбоотой 161,777.5 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 31 хүнтэй холбоотой 86,300.0 мянган төгрөг, чанаргүй зээл 67 хүнтэй холбоотой 100,388.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант жилд 23,033.6 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төвлөрсөн нь ИТХ-аар баталсан дүнгээс хэт бага, зээлийн авлага төвлөрүүлэлт, зээл олголт, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд хангалтгүй байна.	186,688.6	Менежмент захидлаар зөвлөмж хүргүүлэв.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Г.Болормаа, Б.Алтанцэцэг
3	Бараа материалын тодруулга тайлангийн эхний, эцсийн үлдэгдлээр Аж ахуйн материал 24,248.6 мянган төгрөг, Түлш шатах тослох материал 1,253.1 мянган төгрөг, Бусад хангамжийн материал 1,778.1 мянган төгрөг байхад Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн эхний, эцсийн үлдэгдлээр аж ахуйн материал 18,776.0 мянган төгрөг, Түлш шатах тослох материал үлдэгдэлгүй байна. Харин оны эцсийн тооллогын бүртгэлээр аж ахуйн материалын эцсийн үлдэгдэл 18,289.6 мянган төгрөг, түлш шатах тослох материалын эцсийн үлдэгдэл тайлагнагдсанг Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитын явцад залруулсан байна.	9,891.0	Аудитын явцад албан шаардлага хүргүүлэн залруулга хийв.	Засаг дарга, Санхүү албаны дарга	Г.Болормаа, Б.Алтанцэцэг
	ДҮН	199,188.5			

